



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/76

Чойр

Чойр хотын захирагчийн ажлын албаны
орон тооны хязгаарыг тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 6.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12 дахь заалт, Засгийн газрын 1994 оны "Шинээр байгуулагдсан аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, хот тосгодын захирагчийн ажлын албаны тухай" 128 дугаар тогтоол, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 07 дугаар сарын 23-ний өдрийн 06 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Чойр хотын захирагчийн ажлын албаны дүрэм"-ийн 2.1, Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Чойр хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг 8 хүртэл орон тоотой байхаар тогтоосугай.

2.Батлагдсан төсөвт багтаан бүтэц, орон тоог батлаж ажиллахыг Сүмбэр сумын Засаг дарга бөгөөд захирагчийн ажлын албаны дарга (Т.Бат-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4210400185